

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг

Олон улсын эрх зүйд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлтэд хяналт тавих, хууль ёсны эргэлтийг зохицуулах, хууль бус эргэлттэй тэмцэх зорилго бүхий дараах конвенциуд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлагдан хэрэгжиж байна:

- 1961 оны “Мансууруулах эмийн тухай” конвенц;
- 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” конвенц;
- 1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенц.

Монгол Улс дээрх конвенциудад нэгдэн орсон бөгөөд ингэснээрээ мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар эдгээр конвенцуудад заасан үүрэг хүлээж, энэ чиглэлээр дотоодын хууль тогтоомжоо олон улсын эдгээр гэрээний зохицуулалтад нийцүүлэх үүрэг хүлээсэн билээ.

Мансууруулах бодисыг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний зорилго бүхий хэрэглээгээр хязгаарлах, энэ зорилгод хүрэхэд олон улсын хамтын ажиллагаа шаардлагатайг онцолж, өмнө үйлчилж байсан олон улсын гэрээнүүдийг нэгтгэн, нэгдсэн нэг конвенц болгон баталсан нь 1961 оны “Мансууруулах эмийн тухай” конвенц юм. Уг конвенцоор мансууруулах бодисыг хянах олон улсын механизмыг бий болгосон бөгөөд мансууруулах бодисын ангиллыг гаргаж, ангилал тус бүрд хамаарах мансууруулах эм, бэлдмэлийн хэрэглээнд тавигдах хяналтын хэлбэрүүдийг тодорхойлсон ба нэгдэн орсон улс орнууд уг конвенцид нийцсэн дотоодын хууль тогтоомжийг батлан мөрдүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

1961 оны “Мансууруулах эмийн тухай конвенц”-ийн үйлчлэх хүрээ, хяналтын тогтолцооноос гадна үлдсэн, тухайн үедээ шинээр бий болж байсан синтетик аргаар гаргаж авсан шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтийг зохицуулах зорилгоор 1971 онд “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан байна. Уг конвенцоор сэтгэцэд нөлөөт бодисын ангилал, хэрэглээний хязгаарыг тогтоосон бөгөөд тус конвенцид нэгдэн орсон улс орнууд I-IV жагсаалтад орсон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, экспортлох, импортлох, түгээх, нөөцлөх, худалдаалах, ашиглах болон эзэмших асуудлыг байнга хяналтандаа байлгах, мөн тэдгээрийн эргэлттэй холбоотой зарим хууль бус үйлдлийг гэмт хэрэгт тооцон хариуцлага хүлээлгэх үүрэгтэй байхаар зохицуулсан.

1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенц нь өмнө дурдсан 2 конвенцоор хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудлыг олон улсын хамтын ажиллагаанд түшиглэн шийдвэрлэх зорилготой юм. Уг конвенцоор мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт гэж юу болохыг тодорхойлон, нэгдэн орсон улс орнуудад дотоодын хууль тогтоомжоор уг үйлдлийг хууль бус гэж тооцохыг үүрэг болгож, дотоодын хууль тогтоомжийг энэхүү конвенцийн зохицуулалттай нийцүүлэх үүргийг

тусгасан.

Тус конвенцид бас нэг чухал асуудлыг тусгасан нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй үр дүнтэй тэмцэх, түүний эсрэг хууль сахиулах арга хэмжээг дээд зэргийн үр дүнд хүргэхийн тулд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөрдөн шалгахтай холбоотой хангалттай эрхийг улс орон бүр дотооддоо шийдвэрлэж хууль тогтоомжоороо зохицуулах үүргийг хүлээлгэсэн байдал юм. Энэ нь хууль сахиулах байгууллагуудын хувьд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үр дүнтэй арга хэрэгслийг бий болгох хөшүүрэг болдог.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодисын комисс хар тамхитай тэмцэх бодлогыг тодорхойлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба түүнийг хэрэгжүүлж, Мансууруулах бодисын олон улсын хяналтын зөвлөл үндэсний хэмжээнд хар тамхитай холбоотой зохицуулалтыг мөрдөж байгаа эсэхийг хянаж, улмаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага мансууруулах төрлийн бодисын жагсаалтад ямар бодис оруулахыг тодорхойлж өгдөг.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотойгоор хүн амын нас баралтын тоо, халдварт өвчин, гэмт хэрэг, авилга, хээл хахууль авсан болон бусдыг хүчирхийлсэн хэрэг ихээр нэмэгдсэн байгаа нь дээр дурдсан конвенцуудын хэрэгжилт, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааг улам илүү үр дүнтэй болгох, улс орон бүр үндэсний хууль тогтоомжийг энэ чиглэлд боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Монгол Улсын хууль тогтоомж, түүний хэрэгжилт болон Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх талаарх практик нөхцөл байдал

Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, түүний эргэлттэй холбогдсон дараах гол хууль тогтоомжууд үйлчилж байна. Үүнд:

1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль (2002 он)

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2024 он)

3. Зөвшөөрлийн тухай хууль (2022 он)

4. Эрүүгийн хууль (2015 он)

5. Зөрчлийн тухай хууль (2017 он)

6. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль (2018)

7. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль (2024 он)

8. Байгалийн ургамлын тухай хууль (1995 он)

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилт, нөхцөл байдлын талаар

2002 онд батлагдсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилттойгоор хуульчлагджээ.

Тус хуульд "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис"-ыг "донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, "Мансууруулах эмийн тухай" 1961 оны НҮБ-ын Конвенци, "Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай" 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэл" гэж, "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт"-ийг "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагаа" гэж, "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх" гэж "байгальд ургадаг мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг түүж цуглуулах, тарьж ургуулах, хураан авах, цэвэршүүлэх, дахин боловсруулж хувирган өөрчлөх, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн хэлбэрээр гаргаж авах"-ыг ойлгохоор тус тус тодорхойлжээ.

Тус хуулийн 4 дүгээр зүйлд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ашиглахтай холбоотой буюу ашиглах зорилго, ашиглах байгууллагын жагсаалт, ашиглах журам, хэрэглэхтэй холбоотой эмчийн заалтаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор авсан өвчтөн уг эмийг хэрэглэж болох зохицуулалтаас өөр зохицуулалтгүй байна.

Мөн тус хуулийн 5 дугаар зүйлд эмчилгээний зорилгоор хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг шаардлага хангасан жороор олгох болон хүн амын тоог харгалзан мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тогтоох асуудлыг тусгажээ.

Ашиглах журам, ашиглах байгууллагын жагсаалтыг Засгийн газраас батлахаар заасан ба үүний дагуу Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах байгууллагын жагсаалт", 3 дугаар хавсралтаар батлагдсан "Шинжилгээ, судалгааны зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ашиглах журам" мөрдөгдөж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор холбогдох байгууллагууд ашиглаж байгаа ч ашиглахаар журамд заасан зарим байгууллагын үйл ажиллагаа зогссон, эсхүл огт үйл ажиллагаа явуулж байгаагүй байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах байгууллагуудад Улсын мэргэжлийн хяналтын байгууллага буюу Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хяналт тавих үүргийг журамд заасан ч уг байгууллага татан буугдсаны улмаас энэхүү чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдийн эрх зүйн орчин тодорхойгүй болсон байна.

Энэ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх харилцаанд хяналтыг бүрэн хэрэгжүүлж хууль бус эргэлт бий болохоос урьдчилан сэргийлэх боломжгүй байдалд хүргэжээ.

Тус хуулийн 6 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль тогтоомжид заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж

ахуйн нэгж Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, экспортлогч, импортлогч талууд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө харилцан гэрээ байгуулсан байх, экспортлогч, импортлогч талуудын байгуулсан гэрээ, тусгай зөвшөөрлийг үндэслэн Засгийн газраас тусгайлан тогтоосон хилийн боомтоор нэвтрүүлэх, хилээр нэвтрүүлэхэд гаалийн удирдах төв байгууллагаас баталсан хяналтын тусгай журмыг мөрдөх, Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тухай бүрд энэ тухай гаалийн байгууллага эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 7 хоногийн дотор мэдэгдэх талаар зохицуулжээ.

Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/81 тоот тушаалаар "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журам"-ыг батлан мөрдүүлж байна.

Хууль болон Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/81 тоот тушаалаар "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журам"-ын зохицуулалт нь хэт ерөнхий байдлаар зохицуулсан гэж үзэхээр байна.

Монгол Улсын хил, боомт дээр ажиллаж байгаа гаалийн байгууллагын алба хаагчид мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж мэдэх, илрүүлэх талаар ойлголт, туршлага багатай, алба хаагчид ойр ойрхон солигддог, ажиллах хүч тогтвортой ажилладаггүй байдал, хүний нөөцийн дутагдалтай байдал болон гаалийн байгууллагын ашиглаж буй техникийн эвдрэл, технологийн хоцрогдол, хангалтгүй буюу хүрэлцээгүй байдал нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд бүрэн хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна.

Тус хуулийн 7 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг зохих шаардлага хангасан байр, агуулахад хадгалах бөгөөд сав, баглаа боодол нь түүний бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр хийгдсэн байхаар, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагын хяналтын үйл ажиллагааны явцад хууль бусаар ашиглаж байгааг илрүүлэн хурааж авсан бөгөөд цаашид ашиглах чанарын шаардлага хангахгүй бол, мөн эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж байсан болон нөөцөлж хадгалсан боловч хэрэглэх хугацаа дууссан, чанараа алдсан бол, мөн сав, баглаа боодол нь шошго, нэр хаяггүй бол устгах зохицуулалтыг тусгаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журмыг Засгийн газар батлахаар заажээ. Үүний дагуу Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журам" мөрдөгдөж байна.

Журамд заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагын даргын шийдвэрээр тусгай комисс томилогдож хүчинтэй хугацаа дууссан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг устгах ажиллагаа явагдах ёстой ч өдгөө тус ажиллагаа хэрхэн явагдаж байгаа нь тодорхойгүй байна.

Тус хуулийн 8 дугаар зүйлд Монгол Улсын нутаг дэвсгэрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эмчилгээ, шинжилгээ, судалгаа, лабораторийн шинжилгээ хийх, сургалт явуулах, харьцуулалт хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх, эмчийн заалтаар хэрэглэхээс бусад зориулалтаар үйлдвэрлэх, худалдах, ашиглах, хэрэглэхийг хориглож, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх

байгууллагын худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгох, тусгай зөвшөөрөл авахыг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах шаардлага, тусгай нөхцөлийг хангасан агуулахтай байх бөгөөд уг агуулахын талаар эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргах талаар тусгажээ.

Мөн тусгай зөвшөөрлийг 3 жилээр олгохоор, тусгай зөвшөөрөлтэй холбогдох бусад харилцааг Зөвшөөрлийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулахаар заасан байна.

Тус хуулийн 9 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллага болон Үндэсний хороонд тус тус хүргүүлэхээр тусгажээ.

Гэвч дээрх байгууллагуудаас тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавьдаг болох нь тодорхойгүй байна. Хуульд энэхүү хяналтыг аж ахуй нэгжийн гаргах тайлангаар дамжуулан хэрэгжүүлэх тухай заасан боловч тайланд юуг дурдах, тайлангийн дагуу бодит байдалд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар зохицуулалтгүй байна.

Тус хуулийн 12 дугаар зүйлд мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчлэх, мансуурах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхээр зааснаас өөр зохицуулалтгүй байна.

Мансууруулах бодист донтсон этгээд нь сайн дурын үндсэн дээр эмнэлэгт хандах тохиолдолд хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байгаагаас практикт сайн дураараа эмнэлгийн үйлчилгээ авахаар эмнэлэгт хандахаас зайлсхийдэг байна. Иргэд цагдаагийн байгууллагад бүртгүүлэхгүйн тулд эмчилгээ хийлгэхээс татгалзах явдал түгээмэл байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12.2-т хуулиар албадан эмчлэх тухай зохицуулсан боловч тийнхүү албадан эмчилсэн тухай мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Донтох эмгэг судлалын клиникийн амбулаторийн буюу өдрөөр эмчлүүлсэн болон хэвтэж эмчлүүлсэн статистик үзүүлэлтээс авч үзвэл мансууруулах бодист донтсон этгээдийн өвчлөл нь сүүлийн жилүүдэд хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотод харьцангуй өссөн үзүүлэлт бүртгэгдсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн эмчилгээний стандартын F19:Олон төрлийн сэтгэцэд нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгт хамгийн их буюу 283 тохиолдол бүртгэгдсэн байгаа нь донтогчдын хувьд нэг төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх бус бусад төрлүүдийг хамтад нь хэрэглэх тохиолдол ихэссэн байгааг харуулж байна.

Мөн дээрх эмчилгээнд хамрагдсан тохиолдлуудыг насны ангиллаар авч үзвэл 20-29 насныхан дийлэнх хувийг эзэлж байна. Иймд нийгмийн энэ бүлгийг хамарсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмд донтохоос урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Эмчилгээний үр дүнгийн хувьд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээллээр 2019-2023 оны хооронд 30 хүн давтан эмчлүүлсэн бол сүүлийн хоёр жилийн хугацаанд давтан эмчлүүлсэн хүний тоо харьцангуй өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь мансуурах бодист донтсон эмчлүүлэгчид бүрэн эмчлэгдэж чадахгүй байгаагийн илрэл юм.

Тус хуулийн 12 дугаар зүйлээр дараах үйл ажиллагаануудыг хориглосон байна:

- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг шуудангийн илгээмжээр явуулах;
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх;
- мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг жоргүйгээр болон хүчингүй жороор олгох, түүнчлэн жоронд заасан тоо, хэмжээнээс илүү олгох;
- эмчилгээнд хэрэглэх жагсаалтад орсноос бусад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх;
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн эмчийн заавар, жоргүйгээр хэрэглэх;
- тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгж хоёр талын гэрээнд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг төстэй өөр зүйлээр орлуулах болон зөвшөөрсөн тоо, хэмжээг хэтрүүлэн Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тусгай зөвшөөрөлгүйгээр импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хадгалах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг насанд хүрээгүй хүнд худалдах, олгох;
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хүүхдийн бусад байгууллага байрладаг нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, хадгалах.

Тус хуулийн 14, 15 дугаар зүйлүүдэд Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, гааль, хил, цагдаа, тагнуулын байгууллагын болон Үндэсний хорооны үүргийг тусгайлан тусгаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагад зайлшгүй шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс гаргахаар, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор амьтан сургах, хяналтын болон лабораторийн шинжилгээний техник хэрэгслээр хангахад төрөөс зохих дэмжлэг, хөнгөлөлт үзүүлнэ гэж заасан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн бодлого тодорхойгүй байгаагаас хуулийн дагуу үүрэг хүлээсэн байгууллагуудын урьдчилсан сэргийлэх ажил нь зөвхөн олон нийтэд хандсан мэдээлэл, сурталчилгаагаар хязгаарлагдаж байна. Олон нийтэд түгээж буй сурталчилгааны агуулга нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлахад чиглэж байгаа нь учир дутагдалтай байна. Энэ нь олон нийтэд энэхүү зан үйлээс татгалзуулах, зайлсхийх хандлагыг бий болгоход эсрэг үр дүнг үзүүлж байж болохыг өдий хүртэл холбогдох гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурахгүй байгаатай холбож авч үзэж болох юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг хянах, таслан зогсоох тухайд хуульд заасан дээрх байгууллага бүр хүлээсэн үүргийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ч үр дүн хангалтгүй байгаа нь тус хуулиар зохицуулж буй харилцааны хурдтай өөрчлөлттэй холбоотой. Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг хянах, таслан зогсоох чиглэлээр салбар хоорондын уялдааг хангах зайлшгүй шаардлагатай байна.

2002 онд батлагдан одоог хүртэл мөрдөгдөж байгаа Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль нь НҮБ-ын 3 конвенцид туссан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын зарим хууль ёсны эргэлтийг зохицуулсан цөөн тооны зохицуулалттай буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын бүх хууль ёсны эргэлтийг хангалттай тодорхой зохицуулаагүйгээс гадна олон улсын гэрээнд тусгагдаагүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон урвуулан хэрэглэж мансуурах эрсдэлтэй бодис, мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн сайн дураар эмчилгээнд хамрагдахтай холбогдуулан эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, эмчлэх арга зүй, тогтолцооны талаар оновчтой тодорхой зохицуулалтгүй байгаа юм.

Зөвшөөрлийн тухай хууль (2022 он)

Тус хууль нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох нийтлэг харилцааг зохицуулах зорилттой.

Зөвшөөрлийн тухайд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох дараах үйл ажиллагааг эрхлэхэд зөвшөөрөл авахаар тусгагдсан байна:

- 1.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх-экспортлох /хүнд зориулсан эм/;
- 2.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм импортлох-ханган нийлүүлэх /хүнд зориулсан эм/;
- 3.мансууруулах эм худалдах /хүнд зориулсан эм/.

Мөн хүн, хуулийн этгээд нь хуулиар хориглосон, эсхүл тус хуульд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болохоор тус хуульд заасан байна.

Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт дэх дээр дурдсанаас бусад үйл ажиллагааг хүн, хуулийн этгээд чөлөөтэй эрхлэх хууль зүйн нөхцөл байдал бүрдсэн гэж үзэхээр байна. Тухайлбал, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх үйл ажиллагааг эрхлэхэд зөвшөөрөл шаардах хуулийн зохицуулалт байхгүй байгаа нь тус үйл ажиллагааг хүн, хуулийн этгээд зөвшөөрөлгүйгээр, чөлөөтэй эрхлэх боломжтой байна.

Тус хуульд заасан зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллага хооронд зөвшөөрөл авах, олгох харилцаанд Зөвшөөрлийн тухай хууль хамаарахгүй байхаар зохицуулжээ.

Эрүүгийн хууль (2015 он)

Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох дараах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна:

1. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах (16.2)
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах (20.7)
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах (20.8)
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших (20.9)
5. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах (20.10)

16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах

Хүүхдийг байнгын согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж хүндрүүлэхээр заасан байна.

Энэ нь хүүхдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай байдалд татан оруулсан үйлдлийг согтуурах байдалд татан оруулсан үйлдэлтэй адил ял ногдуулахаар заасныг анхаарах нь зүйтэй байна.

Түүнчлэн тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд тус гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан болон хохирогч нас барсан нөхцөл байдлыг ялын ижил санкцитайгаар хуульчилсан байгааг мөн анхаарах шаардлагатай.

20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг

Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийг байнга тогтвортой, мөн улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 12 жилээс 20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж 40 000 нэгжээс 200 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэхээр байна.

20.8 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах гэмт хэрэг

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангасан бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

20.9 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших гэмт хэрэг

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хасаж 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ялын шийтгэлтэй байна.

20.10 дугаар зүйл.Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэрэг

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан бол 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр,

тус гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж 40 000 нэгжээс 200 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэхээр хуульчилсан байна.

Эрүүгийн хуулийн дээрх заалтаас үзвэл мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой:

- хүүхдийг байнгын мансуурах, донтох байдалд татан оруулсан,
- мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах буюу хууль бусаар бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан, бусдад өгсөн, олж авсан,
- мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангасан,

-мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан,

-мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан үйлдлүүдэд л эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байна.

Өөрөөр хэлбэл бусад буюу хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, түүх, хэрэглэх, ашиглах, бусдад хэрэглэх, бусдад хэрэглүүлсэн, дамжуулах, зуучлах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх тээврийн хэрэгслээр хангах, хууль тогтоомж, журам зөрчиж эргэлтэд оруулсны улмаас хүний эрүүл мэндэд хохирол учрах зэрэг нь гэмт хэрэгт тооцогдохгүй байна.

Улмаар дээр дурдсан гэмт хэргүүдэд ял шийтгэл оногдуулахад хууль бусаар эргэлтэд оруулсан бодисын төрөл, хэмжээг харгалзах шаардлагагүй байгаа нь Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зармыг хангахгүй байна.

Зөрчлийн тухай хууль (2017 он)

Зөрчлийн тухай хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох дараах үйлдлүүдийг зөрчилд тооцохоор хуульчилсан байна:

5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах

Мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

6.4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөлтэй мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, экспортлогч, импортлогч талууд байгуулсан гэрээнд заасан нэр төрөл, тоо, хэмжээнээс хэтрүүлсэн, эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад зохих зөвшөөрөлгүйгээр олгосон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, бүртгэх, хуваарилах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, устгах журам зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн худалдаалсан, зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих

Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, **мансуурсан**, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Энэ нь Зөрчлийн тухай хуульд заасан 5.1 лүгээр зүйлд заасан мансуурсан зөрчилд оногдуулах хариуцлагаас бага санкцитайгаар буюу баривчлах шийтгэлгүйгээр хуульчлагджээ.

10.13 дугаар зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль зөрчих

Хуульд заасныг зөрчиж **хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон ажилд зуучилсан** нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 2000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 20 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг 2021-12-21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон хэдий ч Зөрчлийн тухай хуулийн тус заалт хэвээр үлджээ.

14.6 дугаар зүйл. Автотээврийн тухай хууль зөрчих

Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн жолоочийг замд гарах зөвшөөрөл олгосон бол хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

1. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Жолооч:

-согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

-тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

-согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах санкцитай буюу эдгээр зөрчлүүдэд ижил санкцитай байна.

3. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдээр тээврийн хэрэгсэл жолоодохыг шаардсан, эсхүл нөлөөлсөн бол хүнийг 20 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.11 дүгээр зүйл. Усан замын тээврийн тухай хууль зөрчих

Усан замын тээврийн хэрэгслийн ахмад, багийн гишүүд, өмчлөгч, эзэмшигч, жолооч нь согтууруулах ундаа, **мансууруулах үйлчилгээтэй эм, бодис** хэрэглэсэн үедээ усан замын тээврийн хэрэгсэл жолоодсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд заасан “эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад зохих зөвшөөрөлгүйгээр олгосон”, “зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн худалдаалсан, зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан” зөрчлийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан “худалдаалах зорилгогүйгээр бусдад өгсөн”, “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар илгээсэн, худалдсан” гэсэнтэй давхцаж байх бөгөөд тус үйлдэлд Эрүүгийн хуулиар биш Зөрчлийн тухай хуулийг хэрэглэх боломж бүрдсэн гэж үзэхээр байна.

Гэсэн хэдий ч, хууль хэрэгжиж эхэлснээс хойших 24 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдогчийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байгааг статистик мэдээллээс харж болно. Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль батлагдах үед буюу 2002 онд цагдаагийн байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг нийт 2 бүртгэгдэж байсан бол 2014 онд 62, 2015 онд 79, 2016 онд 98, 2017 онд 222, 2018 онд 200, 2019 онд 258, 2020 онд 204, 2021 онд 187, 2022 онд 230, 2023 онд 238, 2024 онд 254, 2025 онд 307 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Харин энэ төрлийн зөрчлийн тухайд 2017 онд 48, 2018 онд 122, 2019 онд 227, 2020 онд 207, 2021 онд 216, 2022 онд 265, 2023 онд 228, 2024 онд 311, 2025 онд 394 зөрчил тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. 2025 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог өмнөх оныхтой харьцуулахад гэмт хэрэг 20 гаруй хувиар, зөрчил 26,6 хувиар тус тус өсжээ.

2017–2025 оны хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт нийт 2,422 хүн холбогдсон байна. Насны ангиллаар авч үзвэл, холбогдогчдын 4.4 хувийг 13–17 насны өсвөр насныхан, 50.4 хувийг 18–25 насны залуучууд, 35.8 хувийг 26–35 насныхан, 9.2 хувийг 36 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

Боловсролын түвшний хувьд холбогдогчдын 1 хувийг бага ангийн хүүхэд, 11.4 хувийг бүрэн бус дунд боловсролтой, 60.5 хувийг бүрэн дунд боловсролтой, 4.3 хувийг тусгай дунд боловсролтой, 22.2 хувийг дээд боловсролтой иргэд эзэлж байна.

Нийгмийн байдлын хувьд дээрх холбогдогчдын 59.5 хувийг ажилгүй, 18.7 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8.9 хувийг оюутан, 7.8 хувийг хувийн хэвшлийн ажилтан, 2.6 хувийг сурагч, 0,9 хувийг төрийн бус байгууллагын ажилтан, 0,7 хувийг төрийн албан хаагч, 0,08 хувийг орон гэргүй, 0,04 хувийг хорих ял эдэлж буй иргэд эзэлж байна.

Харин 2017-2025 онд зөрчлийн хэрэгт нийт 1976 хүн холбогдсон ба үүний 20,9 хувийг 13-17 насны хүүхдүүд, 50,6 хувийг 18-25 насны, 21,6 хувийг 18-35 насны залуучууд тус тус эзэлсэн бол 6.8 хувийг 36-аас дээш насны иргэд эзэлжээ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэргийн улмаас гадаад улсад Монгол Улсын нийт 47 иргэн хорих ял эдэлж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 30 иргэн ял эдэлж байгаагаас Бээжин хотод 3, Хөх хотод 21, Хонгконгт 6 хүн тус тус хоригдож байна. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсад 6, Бүгд Найрамдах Турк Улсад 5,

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2, Малайз Улсад 2, Япон Улсад 1, Камбож Улсад 1 иргэн хорих ял эдэлж байна.

Ялын хэмжээний хувьд 1 иргэн бүх насаар хорих ял шийтгүүлсэн бол 25-аас дээш жилийн хорих ялаар 4, 20–25 жилийн хорих ялаар 5, 10–19 жилийн хорих ялаар 18, 1–9 жилийн хорих ялаар 5 хүн тус тус шийтгүүлжээ. Харин 15 иргэний хувьд хорих ялын хугацаа тодорхойгүй байна. Эдгээр тоон мэдээллээс үзэхэд гадаадын улс орнуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт ялын хатуу бодлого баримталж буй нь харагдаж байна.

Харин Монгол Улсад сүүлийн 7 жилд гадаад улсын 12 иргэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шалгагдсанаас Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэн 2-4 жилийн хорих ялаар тус тус шийтгүүлжээ.

2006–2010 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн дийлэнх хувийг дотоодод ургадаг мансууруулах үйлчилгээтэй олсны ургамалтай холбоотой гэмт хэрэг эзэлж байсан бол 2011 оноос эхлэн энэ төрлийн гэмт хэргийн шинж, бүтэц өөрчлөгдөж, химийн аргаар боловсруулсан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт синтетик бодисын хэрэглээ нэмэгдэх хандлага ажиглагдах болсон. Түүнчлэн зарим төрлийн эм, эмийн бэлдмэлийг зориулалтын бусаар, урвуулан хэрэглэж мансуурах тохиолдол өсөж, үүний улмаас иргэд эрүүл мэндээрээ хохирох, цаашлаад амь насаа алдах эрсдэл бий болж байна.

Тухайлбал, 2017-2025 онд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсний улмаас 26, энгийн эм /Тебантин/-ийг мансуурах зорилгоор урвуулан хэрэглэсний улмаас 11, мөн ахуйн хэрэглээний газ хэрэглэж мансуурсны улмаас 12, нийт 49 хүн нас барсан тохиолдол бүртгэгджээ.

Сүүлийн 8 жилийн хугацаанд нийт 17 төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт болон урвуулан хэрэглэх эрсдэлтэй эм, бодис буюу каннабис 587 кг, гашиш 9,379 гр, мөс 12,511 гр, экстази 247 ширхэг, JWH-018 (ADB-Butanica) 840 мл, CBD-OIL 376 мл, THC агууламжтай чихэр 61 ширхэг, LSD 1328 ширхэг, DXM 1,059 гр, 146 ширхэг, Мими 11,050 гр, тебантин эм 7091 ширхэг, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм 3,631 ширхэг, 261 гр, efetrin hidroklorur 500 гр, героин 200 гр, DHG 10 ширхэг, pinasa 15 мл хураагдсан байна. Үүнийг мансууруулах үйлчлэлийн хүн/тунгаар илэрхийлбэл ойролцоогоор 419,293 хүн/тунгаар тэнцэхээр байна.

Дээрх тоо баримт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилтыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалт хангаж чадахгүй байгааг харуулж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ манай улсад өсөн нэмэгдэж байгаа нь хүний эрүүл мэнд болон улс орны үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засаг, соёлын үндэс, тогтвортой байдалд ноцтой аюул занал учруулж, үр дагавар нь тооцоолохын аргагүй нөхцөл байдалд хүргэж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

Лабораторийн аргаар боловсруулсан, олон улсын гэрээнд тусгагдаагүй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй шинэ төрлийн бодисууд гарсан бөгөөд эдгээрийн нэр, төрөл улам олширч, эдгээр шинэ төрлийн бодис болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ ихсэж, бэлтгэгч, худалдан борлуулагч, тээвэрлэгч, зуучлагч, хэрэглэгчийн сүлжээ үүсээд байна. Манай улсын хууль, эрх зүйн орчин бүрхэг, зохицуулалт дутмаг байгаагаас шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис олон улсын гэрээнд заасан жагсаалтад байхгүй гэдэг үндэслэлээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль ёсны эргэлтийг тодорхой зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэн, хаана, ямар зориулалтаар хууль ёсны эргэлтэд оруулах нь тодорхой бус байгааг анхаарч, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай болжээ. Тухайлбал, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд ашигладаг тайвшруулах, нойрсуулах, мэдээ алдуулах үйлчилгээтэй эм, бэлдмэлийн зохицуулалтыг 2024 онд батлагдсан Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд тусгасан хэдий ч зөвшөөрлийн зохицуулалтыг орхигдуулсан байдаг. Тус эм нь найрлагадаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан байдаг тул зөвшөөрөлгүйгээр улсын хилээр оруулж ирэх, ханган нийлүүлэх боломжгүй болж, мал, амьтны тайвшруулах, нойрсуулах, мэдээ алдуулах үйлчилгээтэй эмийг хүнд зориулсан эм, бэлдмэлээр орлуулан бүртгэл, хяналтгүйгээр ашиглах байдалд хүрсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гишүүн улс бүр мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүний хор уршгийг арилгах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг идэвхтэй зохион байгуулах шаардлагатайг сануулж, энэ чиглэлийн ажлаа эрчимжүүлэхийг зөвлөсөн байна. Мөн тус албанаас 2010 онд гаргасан тайланд Монгол Улсыг хар тамхи “дамжин өнгөрүүлэгч улс” гэж дүгнэж байсан бол 2014 оны тайланд “хэрэглэгч улс” болсон тухай дурджээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус наймаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид заасанчлан үндэстэн дамнасан, нарийн зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга, зохион байгуулалт боловсронгуй болж, үндэстний аюулгүй байдалд аюул, занал учруулах шинжтэй болж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт

Монгол Улсын тухайд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр бодлогын баримт бичгүүдэд дараах зорилтууд тусгагдсан байдаг. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.3.4-т “... архи дан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ” гэж заасан байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн бөгөөд уг зорилтын хүрээнд 2021-2030 онд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ. Тухайлбал,

а/“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.8-д “Хүн амын амьдралын зөв дадал

хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ” гэж, 2.2.9-д “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах ...” гэж;

б/Мөн уг арга хэмжээний 2.2.35-д “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна” гэж, 7.3.6-д “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна” гэж;

в/Түүнчлэн уг арга хэмжээний 7.3.9-д “... мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ” гэж, 7.3.13-т “Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно” гэж тус тус заажээ.

3.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.1.9-д “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасан.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2025 онд боловсруулахаар тусгасан байна.

Иймд дээр дурдсан олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хууль зүйн үндэслэл, Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, нөхцөл байдал, практик хэрэгцээ, шаардлагыг харгалзан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол хуулийн

шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна гэж заасан бөгөөд тус хуулийн төслөөр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн бүтэц, уялдаа өөрчлөгдөж, мөн тус хуулийн 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орсон тул төслийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ нэртэйгээр боловсрууллаа.

Хуулийн төсөл 12 бүлэг, 74 зүйлтэй бөгөөд дараах асуудлыг төсөлд тусгасан. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд баримтлах зарчмын талаар тусгалаа.

Хуулийн зорилтыг:

- 1.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх;
- 2.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах;
- 3.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршихоор хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг 3 дугаар зүйлд тусгалаа. Тухайлбал, "мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис"-ыг шинж байдлаар нь болон олон улсын конвенц, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад төрийн хяналтад байлгах нийлэгжүүлсэн болон байгалийн гаралтай бодис, түүнийг агуулсан эм, эмийн түүхий эд, бүх төрлийн бодис, бүтээгдэхүүн, эд, зүйл, материал, ургамлыг бүгдийг хамруулж ойлгохоор тодорхой тусгав. Энэ нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг манай улс зөвхөн олон улсын гэрээгээр тодорхойлж байгаа эрх зүйн зохицуулалтыг халж, дотоодын хууль тогтоомжоороо тодорхойлохыг зорьсон зохицуулалт болох юм.

Мөн "мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт" гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хилээр нэвтрүүлэх, импортлох, экспортлох, реэкспортлох, худалдах, худалдан авах, олгох, тээвэрлэх, илгээх, хадгалах, хэрэглэх, ашиглах, устгах, олж авах, бусдад өгөх, бусдад болон өөртөө хэрэглэх, бусдад хэрэглүүлэх, дамжуулах, түүгээр үйлчлэх, эдгээрт зуучлах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал тарималжуулах, түүх болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох аливаа үйл ажиллагааг гэж эргэлтэд орж болох бүхий л үйлдлийн хэлбэрүүдийг ойлгохоор тусгалаа.

Хоёрдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай, нэн түрүүнд санхүүжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай тусгав.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхийн тулд, мөн олон улсын гэрээнд заасан үүргээ биелүүлэх үүднээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг бүрэн хянах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлыг эрт шатанд илрүүлэх, мансуурах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эрүүл мэндийн болон сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх

тусламж, үйлчилгээ үзүүлэх, сөрөг зуршлаас татгалзуулах, нийгэмшүүлэх цогц оновчтой аргаар мансуурах, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэгчийн тоог бууруулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах бодлого баримталж байхаар тусгалаа.

Үүнтэй уялдуулан энэхүү төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг мөн тусгалаа. Тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг бүрэн хянахын тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой бүх үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулах арга хэмжээг тусгав.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлыг эрт шатанд илрүүлэх, мансуурах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эрүүл мэндийн болон сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, сөрөг зуршлаас татгалзуулах, нийгэмшүүлэх цогц оновчтой аргаар мансуурах, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэгчийн тоог бууруулах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралт байдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох, эмчлэх шинэ төрлийн арга хэрэгсэл, эмчилгээний эмнэл зүйн удирдамж, арга зүйг олон улсын жишигт нийцүүлэн бий болгох, нэвтрүүлэх, тэдгээрийг эмчилгээнд нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын ажлыг төрөөс дэмжих, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэгчийн тоог бууруулах, хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа болон тэнссэн, зөрчлийн арга хэмжээ авагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнийг эмчлэх, нийгэмшүүлэх, ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй зохион байгуулах, тэдгээрт тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай, хэрэглэсэн хүн сайн дураараа эмчилгээнд хамрагдах боломж бүрдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, нэгдсэн мэдээллийн санг бий болгох зэрэг арга хэмжээг тусгалаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрийн болон Засгийн газрын бус байгууллага, олон нийт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахын эсрэг хүн, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжих, эрүүл амьдралын хэв маяг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үл тэвчих дадлыг сурталчлах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эргэлтэд оруулах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд, эмийн жороор хэрэглэх эрхтэй хүн өөрийн хэрэгцээнд шаардлагатайгаас илүү хэмжээний мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг өөрийн өмчлөл, эзэмшилд төвлөрүүлэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, эрүүл мэнд, сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын бүтэц, орон тоог бэхжүүлэх, хүний нөөцийг сургаж мэргэшүүлэх, шаардлагатай барилга байгууламж, лаборатори, тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгслээр хангах зэрэг арга хэмжээ авч байхаар тусгав.

Төрийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний хороо ажиллаж, тус хороо Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар тандалт судалгааг хоёр жил тутам зохион байгуулж хэрэгжүүлж байхаар тусгасан.

Төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг биелэлтийг хангах нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах зорилгоор улсын төсвөөс зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг мөн тусгалаа. Тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх, тодорхойлох өндөр хүчин чадалтай, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах, цагдаа, тагнуул, гааль, хил хамгаалах, шүүх шинжилгээ, эрүүл мэндийн байгууллагын ажилтныг гадаад улсад мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулах, эмнэлгийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж бодис худалдан авах, улсын хэмжээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын тархац, нөөцийн судалгааг гаргах, тогтмол устгал хийх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн хүн, хуулийн этгээдийг урамшуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн нөхцөл байдал, шалтгаан, үр дагаврын талаар мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаар судалгаа хийлгэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг ашгийн төлөө бус хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх, хилийн боомт бүрийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх, шуурхай шинжлэх техник хэрэгсэл, боломж нөхцөлөөр хангах үйл ажиллагааг улсын төсвөөс зайлшгүй санхүүжүүлж байхаар тусгалаа.

Гуравдугаар бүлэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалттай байх, жагсаалтад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын 3 ангилалтай байхаар тусгалаа. Үүнд:

Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах, хэрэглэхийг хориглосон, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглаж, хэрэглэдэггүй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг А ангилалд, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналттайгаар ашиглаж, хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг Б ангилалд, тухайн бодисыг урвуулан хэрэглэснээр мансууруулах, сэтгэцэд нөлөө үзүүлэх эрсдэлтэй эм, бодисыг В ангилалд оруулахаар тусгасан.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын угтвар бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын жагсаалттай байх, тус жагсаалт болон дээр дурдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт, ангиллыг Засгийн газар батлахаар тусгалаа.

Засгийн газраас баталсан жагсаалт дахь бодисын ангиллаас хамааруулан тухайн бодисын эргэлтийг мөн тодорхойллоо. Ингэхдээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар бодисыг ангилал үл харгалзан хуульд зааснаас бусад тохиолдолд эргэлтэд оруулахыг хориглох, улмаар “А” ангилалд заасан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмийн түүхий эдийн үйлдвэрлэлд ашиглах, тус бодистой холбогдуулан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, эргэлтэд оруулах болон хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглож тусгалаа.

Мөн шинэ төрлийн бодисыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмийн түүхий эдийн үйлдвэрлэлд ашиглах, тус бодистой холбогдуулан үйл ажиллагаа эрхлэх

зөвшөөрөл олгох, эргэлтэд оруулах, хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглож тусгаад байна.

Дөрөвдүгээр бүлэгт мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүний төрлүүд, зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага, зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахад бүрдүүлэх баримт бичиг, зөвшөөрөл олгох, олгосныг мэдэгдэх, зөвшөөрлийн хугацаа, хугацааг сунгах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглох, зөвшөөрлийг хүчингүй болгох, зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагааны тайлан болон тайланг хадгалахтай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Зөвшөөрлийн төрлүүдийг эмийн хууль ёсны эргэлттэй уялдуулан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, экспортлох, реэкспортлох, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ханган нийлүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм худалдах, олгох эмийн сангийн үйлчилгээ эрхлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар түүх гэсэн төрөлтэй байхаар тодорхойллоо.

Түүнчлэн зөвшөөрөл эзэмшигч дараа онд ашиглах хэрэгцээт бодисын мэдээллийг өгч байх зохицуулалтыг тусгалаа. Тус зохицуулалт нь олон улсын гэрээний дагуу НҮБ-д манай улс жил бүр хэрэгцээт бодисын тоо хэмжээг мэдэгдэж байх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор тусгагдсан юм.

Мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тээвэрлэлтийн хууль ёсны байх асуудлыг шийдвэрлэхдээ зөвшөөрөл бүхий этгээд үйл ажиллагааныхаа хүрээн дэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тээвэрлэлтийг хариуцахаар тусгалаа.

Зөвшөөрөл эзэмшигчийн зарим үүргийг тодорхой болгохыг зорилоо, тухайлбал, зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулах байршлын талаарх мэдээллийг ажлын 3 өдрийн дотор, байршлыг өөрчилсөн тохиолдолд шинэ байршлын талаарх мэдээллийг ажлын 3 өдрийн дотор цагдаагийн төв байгууллагад хүргүүлэх үүрэг хүлээлгэсэн, ингэснээр олон улсын гэрээгээр хүлээсэн зөвшөөрөл эзэмшигчийн байр, байршлыг хяналтад байлгах үүргээ биелүүлэх юм. Мөн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, төрөл, тоо хэмжээ, хүлээн авахаас зарцуулах хүртэлх буюу өөрийн эзэмшлээс гаргах хүртэлх эргэлтийг тухай бүр тэмдэглэж, бүртгэл хөтлөх үүрэг хүлээлгэсэн ба энэ нь мөн олон улсын гэрээгээр хүлээсэн бүртгэх, тайлагнах үүрэгтэй холбоотойгоор тусгагдсан болно.

Түүнчлэн олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбогдуулан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн зөвшөөрөл эзэмшигч болон ашиглах эрх бүхий байгууллагад ханган нийлүүлж хүлээлгэн өгөх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах, олгох эмийн сангийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасны дагуу, зөвхөн холбогдох эмийн жороор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм худалдах, олгох, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн зөвшөөрөл бүхий этгээдээс худалдан авах болон бусад хэлбэрээр хүлээн авах, тайланг хуульд заасны дагуу, үнэн зөв, бүрэн гаргаж хүргүүлэх зэрэг үүргийг хүлээлгэхээр тусгасан.

Тус зохицуулалттай холбогдуулан зөвшөөрөл эзэмшигч нь эргэлтэд оруулсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, ханган нийлүүлсэн, түгээсэн, худалдсан, олгосон,

хадгалсан, устгасан тайланг бодис бүрээр, улирал тутам гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор цагдаагийн байгууллагын Хар тамхитай тэмцэх албанд болон зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр, Хар тамхитай тэмцэх алба тайланг тодорхой мэдээллээр нэгтгэн Үндэсний хороонд тодорхой хугацаанд тогтмол хүргүүлж байхаар тусгалаа.

Тус тайлангуудыг хадгалах этгээд болон хугацааны зохицуулалтыг мөн тусгалаа.

Тавдугаар бүлэгт мансууруулах, эмийн түүхий эд үйлдвэрлэх, экспортлох, импортлох, реэкспортлох, хилээр нэвтрүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа эрхлэх буюу ханган нийлүүлэх, эмийн жор олгох, эмийн сангаас худалдах, олгох, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар түүхтэй холбоотой тус бүрийн нарийвчилсан зохицуулалт буюу эргэлтэд оруулахтай холбоотой нөхцөл, журам, хориглох зохицуулалтыг тусгалаа.

Тухайлбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх зөвшөөрөл эзэмшигч байх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмийн түүхий эд үйлдвэрлэлийн зориулалтаар зөвхөн Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх нөхцөлтэй байхаар тусгав. Түүнчлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулж байх үүднээс зөвшөөрөл эзэмшигч нь үйлдвэрлэсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын орц, найрлага, түүний эзлэх хувь, төрлийн талаар эмийн магадлан итгэмжлэгдсэн лабораториор жилд нэг удаа шинжлүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, мал, амьтны зориулалттай эм, эмийн түүхий эд бол мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж байхаар тусгалаа.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг экспортлох, импортлохтой холбоотой зохицуулалтыг тусгахдаа Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсноос бусад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, экспортлохыг хориглож, мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис экспортлох, импортлох зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын эм, эмийн түүхий эдийн бүртгэлд орсон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эм, эмийн түүхий эд үйлдвэрлэлийн зориулалтаар, импорт, экспортын мэдүүлгээр импортолж, экспортолж байх гэх зэргээр эргэлтийн хэлбэр бүрт тохирсон зохицуулалтыг тусгав.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, хүнд зориулсан эм олгох жор олгох зохицуулалтыг хуульд тодорхой тусгахыг зорьж тус жорыг зөвхөн эмчлэх эрх бүхий их эмч үйлдэхээр, мөн эмчилгээний тунгаар орсон нийлмэл найрлагатай эм олгоход ч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмийн жор олгохоор, жорд тусгах мэдээлэл, жорын маягт, түүнийг үйлдэх, түгээх, жорын маягтны захиалга, жорын маягтын зарцуулалтыг тайлагнах, Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, мөн эмчилгээний стандартаар тухайн эмийг хэрэглэх заалтгүй тохиолдолд жор бичиж олгох, нэг жорд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм хамт бичих зэргийг хориглохоор тусгалаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмийг эмийн сангаас олгох зохицуулалтыг тодорхой тусгахыг зорьж зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис худалдах, олгох зөвшөөрөлтэй эмийн сангаар худалдах, олгох, ингэхдээ зөвхөн эмийн

жороор, Монгол Улсын эмийн бүртгэлд орсон эмийг олгохоор тусгалаа. Мөн эмийн сангаас эм олгохыг хориглох тохиолдлыг тусгах зэргээр үйл ажиллагаа бүрээр зүйл тус бүрт нь холбогдох нөхцөлийг заасан болон хориглох зохицуулалтыг тусгалаа.

Зургаадугаар бүлэгт Олон улсын гэрээнд заасан Засгийн газрын мэдэлд байдаг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тусгай нөөцийн зохицуулалтыг дотоодын хууль тогтоомждоо тодорхой тусгахыг зорилоо. Тус тусгай нөөц нь одоо практикт байгаа хэдий ч холбогдох эрх зүйн орчин тодорхой бус, бүртгэл, тайлан, хяналтын тогтолцоонд ороогүй байна. Тусгай нөөцийн асуудлыг эрдэм шинжилгээ, судалгааны эрх бүхий байгууллага эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар, эрх бүхий шинжилгээний байгууллага шинжилгээний зориулалтаар, хууль сахиулах буюу хил хамгаалах, гааль, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага сургалтын зориулалтаар, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, зэвсэгт хүчин, төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зориулалтаар, улсын нөөцийн салбар хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зориулалтаар улсын нөөцөд, эрх бүхий байгууллага гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглахтай холбоотой тус бүрийн зохицуулалтыг тусгалаа.

Тус зохицуулалтын хүрээний байгууллага буюу ашиглах эрх бүхий байгууллага нь өөрийн үйл ажиллагааны хүрээн дэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг бүртгэх, дотоод хяналт хийж байх, тайлагнах, тээвэрлэлтийг нь хариуцах зэрэг зохицуулалтыг тусгав.

Эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар ашиглах эрдэм шинжилгээ, судалгааны эрх бүхий байгууллага, шинжилгээний зориулалтаар ашиглах эрх бүхий шинжилгээний байгууллага, сургалтын зориулалтаар ашиглах хил хамгаалах, гааль, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жагсаалтыг Засгийн газар батлахаар, ашиглах эрх бүхий байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах, зарцуулах, устгах, хяналт тавихтай холбоотой журмыг мөн Засгийн газраас батлахаар тусгалаа.

Долоодугаар бүлэгт Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хадгалалт, тээвэрлэлт, устгалын тухай тусгалаа.

Тус бүлгийн зохицуулалт нь зөвшөөрөл эзэмшигч болон ашиглах эрх бүхий байгууллагад мөрдөгдөх юм.

Ашиглах эрх бүхий байгууллага болон зөвшөөрөл бүхий этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хуульд заасан нөхцөл, журам, стандарт шаардлагын дагуу хадгалах, ингэхдээ хадгалах өрөө, шүүгээ, хаяг шошго, хамгаалалтын арга хэмжээ авсан байх, лац тэмдэгтэй байх, акт үйлдэж хүлээн авсан байх, тооллого хийж байх, бүртгэл хөтлөх, бүртгэлийг архивт шилжүүлэх зэрэг зохицуулалтыг тусгав.

Ашиглах эрх бүхий байгууллага болон зөвшөөрөл эзэмшигч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль, стандартад заасан хадгалах нөхцөл, шаардлагыг хангаж тээвэрлэхээр тусгалаа. Гэхдээ тус шаардлагыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагаас үзүүлэх дуудлагын яаралтай тусламж, үйлчилгээ болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс дуудлагын тусламж, үйлчилгээнд хэрэглэх, эмийн сангаас жороор авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эмийг бие болон тээврийн хэрэгсэлдээ авч явахад хамаарахгүй байхаар тусгалаа.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг шуудан, илгээмжээр илгээх, зориулалтын бус тээврийн хэрэгслээр болон зөвшөөрөлгүй этгээдээр тээвэрлүүлэхийг хориглохоор тусгав.

Ашиглах эрх бүхий байгууллага болон зөвшөөрөл бүхий этгээд нь хэрэглэх хугацаа дууссан, чанараа алдсан, үйлдвэрийн технологийн зааврын дагуу хийгдээгүй, чанарын баталгаажуулалтгүй, сав, баглаа боодлын битүүмжлэл, бүрэн бүтэн байдал алдагдсан, эсхүл шошго, нэр хаяггүй, үйлдвэрийн сав боглоо боодол, хаяг шошго алдаатай, хадгалалтын горим алдагдсан, нас барсан өвчтөн хэрэглэж байсан эмийн үлдэгдэл, төрөл, бүтэц, орцыг тодорхойлох боломжгүй, дахин ашиглах, хэрэглэх боломжгүй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эм, эмнэлгийн хэрэгслийн, эсхүл мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Хар тамхитай тэмцэх албатай хамтран устгахаар тусгалаа. Устгахдаа эм, эмнэлгийн хэрэгслийн болон мал, амьтны эрүүл мэндийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн устгалын комиссыг тухай бүр томилон, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулан устгах, Хар тамхитай тэмцэх албаны төлөөлөл, эм, эмнэлгийн хэрэгслийн, эсхүл мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагч байлцуулах, устгасан талаарх акт, дуу-дүрсний бичлэг зэрэг бусад баримт бичгийг арван жил хадгалахаар үүрэгжүүлэн тусгаад байна.

Тус бүлэгт мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгах арга хэмжээний талаарх зохицуулалтыг мөн устгасан бөгөөд тус зүйлд тус ургамлыг устгах онцлог зохицуулалт, устгалд оролцох шаардлагатай байгууллагуудаас авах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгалаа. Тухайлбал, байгалийн болон тарималжуулсан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг нэн даруй, эсхүл үрлэхээс нь өмнө устгах арга хэмжээг энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлэхээр, Хар тамхитай тэмцэх алба нь ургамлын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран жил бүр мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын ургалтад үзлэг хийж, устгах хэмжээ, байршлыг тогтоож байхаар, газар тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тариалангийн бүс нутагт тархан ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг цагдаа, байгаль орчин, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага, нутгийн удирдлагын байгууллагатай хамтран холбогдох удирдамж, заавар, зөвлөмж, аргачлалын дагуу гүйцэтгэхээр, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газар тариалангийн бүс нутгаас бусад газарт тархан ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг цагдаа, байгаль орчин, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага, нутгийн удирдлагын байгууллагатай хамтран холбогдох удирдамж, заавар, зөвлөмж, аргачлалын дагуу гүйцэтгэхээр тусгасан.

Мөн тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч нь тухайн тариалангийн талбайд ургасан болон тариалангийн талбайн захаас гадагш 200 метр хүртэлх зайд орших газарт ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг өөрийн зардлаар устгах үүрэг хүлээлгэлээ.

Наймдугаар бүлэгт мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай тэмцэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх төрийн байгууллагын тогтолцоо, Үндэсний хороо, оролцогч төрийн захиргааны байгууллагууд, нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг уялдуулан тодорхойлохыг зорьж, оролцогч байгууллага тус бүрийн хэрэгжүүлэх шаардлагатай чиг үүргийг тусгалаа.

Есдүгээр бүлэгт мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг эрт илрүүлэх, шинжилгээ хийх эрх бүхий байгууллага, мансуурах, сэтгэцэд нөлөөт

бодисын хамааралтай хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үе шат, төрөл буюу эмийн болон сэтгэл заслын эмчилгээний тусламж, үйлчилгээ, донтох эмгэгийн сэргээн засах эмчилгээ, нийгмийн хамгааллын нөхөн сэргээх арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэгч байгууллагууд, тэдгээрийн чиг үүрэг, ялангуяа донтолттой хүнийг эмчлэх үйл ажиллагаандаа эмчилгээний удирдамж, арга зүй, аргачлалыг баримтлах үүрэг хүлээлгэх зэрэг зохицуулалт тусгалаа.

Донтох эмгэгийн сэргээн засах туламж, үйлчилгээ үзүүлэх Донтох эмгэгийн сэргээн засах төв, аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх байгууллага, тэдгээрийн санхүүжилт, тус эмчилгээг төрөөс хэрэгжүүлэх механизм, санхүүжилтийн талаар тусгалаа. Үүний зэрэгцээ тус тусламж, үйлчилгээг батлагдсан арга, аргачлалын дагуу Засгийн газрын бус байгууллага хийж болохоор тусгалаа.

Донтолттой хүнийг албадан эмчлэх, түүнчлэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүний зан үйлд нөлөөлөх сайн дурын болон албадан сургалтын талаар тусгалаа. Албадан эмчилгээ, албадан сургалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлэхтэй холбоотойгоор албадан сургалт, албадан эмчилгээг донтох эмгэгийн сэргээн засах үйл ажиллагаа явуулдаг төв болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж болох зохицуулалтыг тусгав.

Аравдугаар бүлэгт мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн сангийн төрөл, мэдээллийн санг ашиглах зориулалт, тэдгээрт оруулах мэдээллийн жагсаалт, мэдээлэл оруулах журамтай холбоотой зохицуулалт тусгасан.

Мэдээллийн нэгдсэн сан нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн мэдээллийн сан, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн мэдээллийн сан, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай хүнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийн сан гэсэн 3 төрөлтэй байхаар, сан тус бүрд оруулах мэдээллийн жагсаалт, мэдээллийн сан тус бүрийг хариуцах байгууллагыг тодорхойллоо.

Арван нэгдүгээр бүлэгт Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар буюу хүн, хуулийн этгээдэд хориглох үйл ажиллагааг тодорхойлсон.

Тухайлбал, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхийг сурталчлах, эсхүл уг үйл ажиллагааг дэмжсэн, хууль бус эргэлтэд оруулах арга, хэрэгслийн талаар мэдээлэл агуулсан бүх төрлийн үйл ажиллагаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хэрэглэх, тариалахыг заах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээний талаарх агуулга бүхий болон мэдээлсэн, сурталчилсан кино, тоглолт, дуу авиа, дүрс бичлэг, хуурцаг, ном товхимол, зургийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд, бусдад түгээх, сурталчлах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, зураг, дүрс, тэмдгийг аливаа сурталчилгаа болон кино, тоглолт, дуу авиа, дүрс бичлэг, хуурцаг, ном товхимол, зурагт оруулах, ашиглах зэргийг хориглож, эдгээрт хяналт тавих байгууллагыг тодорхой тусгалаа.

Арван хоёрдугаар бүлэгт гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг цуцалж, албадан гаргах журмын тухай, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх, хууль бусаар ашиглахтай тэмцэх талаар хүн, хуулийн этгээдийн үүрэг, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг зохицуулах, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, түүний зорилт, хэрэгжүүлэх үндсэн зарчим тодорхой болно. Мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдал хангагдаж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар таниулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

2.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүх үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг хуульд тодорхой тусган, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хийдлийг арилган, үйл ажиллагаа явуулах нөхцөл, шаардлага тодорхой болно;

3.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд олон улсын сайн жишигт нийцсэн эрүүл мэнд, сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, сайн дурын үндсэн дээр шинжилгээнд хамрагдах, эмчлүүлэх, эмчлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах зохицуулалт бий болно;

4.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж нэмэгдэнэ;

5.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, үр дүнг үнэлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээнд тогтмол судалгаа, мониторинг хийх мэдээллийн нэгдсэн цахим сан бий болно;

6.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль ёсны эргэлтэд оруулдаг байгууллагуудын хүлээн авсан, зарцуулсан, худалдан борлуулсан бодисын тоо хэмжээ, зориулалтад хяналт тавих, тайлагнах журам хуульчлагдана;

7.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг судлан үзэж, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ, үйлчлэл болон бусад объектив талыг харгалзан ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг Эрүүгийн хуульд заасан “шударга ёсны зарчим”-д нийцсэн ялгамжтай болно;

8.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, тэдгээрийг таслан зогсоох ажилд ахиц, дэвшил гарах төдийгүй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх иргэдийн мэдлэг дээшилж, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон хамааралтай иргэдэд эрүүл мэнд, сэтгэц-нийгмийн сэргээн засах, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.

-----oOo-----

